

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.04.11 - 2022.04.15/

2022.04.15

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
3	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> ✓ Шинэчилсэн бүртгэлд хамрагдах 16 хүний мэдээллийг олж цахим системд оруулсан ✓ Шинэчилсэн бүртгэлд хамрагдах 80 хүний өргөдлийг үүсгэж нэгж талбартай холбоход бэлэн болгосон. ✓ Өдөр бүр шинэчилсэн бүртгэлд хамрагдахаар ирсэн иргэний мэдээллийг шалгаж, цахим бүртгэлд хамрагдах шаардлагатай иргэний өргөдлийг хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.
Газрын удирдлагын хэлтэс		
2	Газрын төлөв байдлын хянан баталгаа, газрын мониторингийн чиглэл	Гэрээ гэрчилгээ шинэчилж, цахим гэрчилгээг 8 нэгж талбарт үүсгэсэн. Захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудас 7 нэгж талбарт хэвлэв. Захиалгат хянан баталгааны 8 тайлан баталгаажуулж 3 тайланг хянаж буцаасан.
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Хүний нөөц, дотоод асуудал, хууль эрх зүй	<p>Хүний нөөц: Газрын Салбарын харилцааны өдрийг тохиолдуулсан төлөвлөгөөт арга хэмжээний дагуу Төрийн дээд, одон медаль, салбарын 5 албан хаагчдыг Шагнал тодорхойлж газрын даргад танилцуулан Газар зохион байгуулалт , геодези зураг зүйн газарт хүргүүлээ.</p> <p>Шүүх хуралдаан:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 2022/03/01-ний өдрийн Дугаар 87 МУ-ын Дээд шүүхийн тогтоолоор Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр баг, 4 дүгээр хороолол, 4 дүгээр байрны оршин суугчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Жаргалсайхан, Ц.Батцацрал нарын нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн аймгийн Засаг даргад холбогдох, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 15 дугаар шийдвэр, Давж заалдах шатны шүүхийн 678 дугаар магадлалыг эс зөвшөөрч нэхэмжлэгч талаас хяналтын журмаар гаргасан гомдлыг хянаад ЗХШХШТухай хуулийн 124.4 заалтаар гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан шийдвэр гаргасан. ✓ “Алтан түрүү” ХХК-ийн нэхэмжлэлтэй ГХБХБГ-т холбогдох Захиргааны хэрэгт, нотлох баримтыг гаргуулж авахаар хүсэлт ирүүлсний дагуу газрын хувийн хэргээс 33 нуур хуудас баримтыг хуулбарлан, хуулбар үнэн тэмдэг дарж хүргүүлээ.
2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 15, Facebook хуудсанд ирсэн 19 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. 2022-04-09-нд 9,10-р багийн төв дээр, 2022-04-10-нд 11, 12-р багийн төв дээр нээлттэй хаалганы өдөрлөг хийхэд оролцов.</p> <p>Мэдээлэл технологийн чиглэлээр: Байгууллагын цахим хуудсан дээр нээлттэй хаалганы өдөрлөгийн тайланг тавив. Байгууллагын Фэйсбүүк хуудсан дээр нээлттэй хаалганы өдөрлөгийн мэдээг 3 удаа байрлуулав. Цахим шилжилтийн брошурыг 700 хувь хэвлэж, хувааж багуудад хуваарилж өгөв. Нээлттэй хаалганы өдөрлөгт явах багуудын компьютерууд дээр VPN-ий тохиргоог хийж, кодыг өгөв.</p>

Тайлан боловсруулсан:
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Хянасан:
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Золбаясах
Г.Нямдорж